

## ТАНИЛЦУУЛГА

1. Банзрагчийн Баярсайханыг Монгол Улсаас Япон Улсад сүүх Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдар томилуулахаар танилцуулж байна

2. 1974 онд Улаанбаатар хотод төрсөн

3. 49 настай

4. Эрэгтэй

5. Гэр булийн байдал: Эхнэр, 3 хүүхэдтэй

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

1997 онд Техникийн Их сургуулийг цахилгаан систем автоматажуулалтын инженер мэргэжлээр, 2017 онд Санхүү, эдийн засгийн Их сургуулийг бизнесийн удирдлагаар магистр, 2020 онд Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийг төрийн удирдлагаар докторын зэрэгтэй тус тус төгссөн. Япон, анили хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал: 1998-2000 онд Япон Улсын "AUCS" компанид инженер, 2000-2002 онд Япон дахь "JP Morgan" компанид хөрөнгийн бирж, хувьцаа арилжааны системийн инженер, 2002-2004 онд "Saison Information Systems" компанид санхүү, мэдээллийн системийн инженер, 2004-2016 онд "Prudent Trust" компанид зөвлөх, захирал, 2006-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны Япон дахь төлөөлөгч, дэд захирал, гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2016-2020 онд Үндэсний хөгжлийн газрын дарга, 2015-2016 онд Улсын Их Хурлын даргын Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хариуцсан орон тооны бус зөвлөх, гадаад бодлогын зөвлөх, 2019-2020 онд "Эрдэнэс-Тавантолгой" хувьцаат компанид Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2020-2022 онд Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны зөвлөх бөгөөд Худалдаа, эдийн засгийн хэлтсийн дарга, 2022 оноос Монгол Улсын Ерөнхий сайдын орон тооны бус зөвлөх, "Монгол-Японы тогтвортой хөгжлийн нийгэмлэг" нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн дарга, Тэргүүнээр ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа (жилээр): Төрийн албанад 8 жил

Дипломат албанад 2 жил

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэспэл:

Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршилага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хা�ших бүрэн боломжтой гэж үзэж байна.

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

Гадаад харилцааны сайдын саналаар

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан: Төрийн захиргааны удирдлагын газрын захирал

Болоесруулсан: Төрийн захиргааны удирдлагын газрын атташе

С.Золжаргал

Л.Халиун

13. Албан тушаалд томилох үед  
өгсөн үүрэг, зөвлөмж

2023 оны 7 дүгээр сарын 25-ны өдөр